

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Эрдэнэ сумын Эрчим хүч” ААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/14/НА-СТА-ААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2021 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор М.Атарцэцэг Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



“Эрдэнэ сумын Эрчим” ААТҮГ-ын
ДАРГА А.МЯГМАРЖАВ ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13.
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.15 № 116

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэ сумын Эрчим хүч” ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол “Эрдэнэ сумын Эрчим хүч” ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар амралт цалин давхардуулан олгосон, урьдчилгаа цалин дутуу суутгасан, төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн, шатахуун илүү зарцуулсан, тендерт шалгараагүй иргэнээс худалдан авалт хийсэн, хамаарал бүхий этгээдээс худалдан авалт хийсэн, нүүрсны зарцуулалтын тооцоог өмнөх онуудтай харьцуулахад 119 тонноор илүү зарцуулсан, батлагдсан төсөв хэтрүүлж алдагдалтай ажилласан зэрэг нийт 141.9 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан. Энэ хуулиар байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Тайлант онд Эрчим хүчний сайдын албан бичгээр “Замын үүдийн дулааны станц” ТӨҮГ-ын уурын зуухны халаалтын тогоог ашиглалтын журмаар авч ашиглах шийдвэр өгч улмаар уурын зуухны тогоог авчрахтай холбоотой 16.4 сая төгрөг зарцуулсан боловч уурын зуухны тогоо ажиллаагүй байна.

0702000273

Аудитын гол асуудал

Говь-Алтай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 113 тогтоолоор “Эрдэнэ сумын Эрчим хүч” ААТҮГ-ын 2022 оны орлого, зардлыг 218.9 сая төгрөгөөр буюу цэвэр ашиг, алдагдалгүй төлөвлөгөөг баталсан. Гүйцэтгэлээр 289.0 сая төгрөгийн зардал гарган 1.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	24,292.16	43,545.57
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	118,377.65	109,316.86
	Нийт хөрөнгийн дүн	142,669.81	152,862.43
	Нийт өр төлбөрийн дүн	38316499.98	31,932,880.00
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	104,353.31	120,929.55
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	38,420,853.29	32,053,809.55
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	7,014.52	32,237.73
	Үйл ажиллагааны зардлын дүн	32,171.75	33,361.73
	Үйл ажиллагааны үр дүн	-25,157.22	-1,124.00
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-25,157.22	-1,124.00
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	129,510.54	122,053.55
	Тайлант оны үр дүн	-25,157.22	-1,124.00
	Эцсийн үлдэгдэл	104,353.31	120,929.55
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	209,302.27	288,271.26
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	219,331.84	274,071.17
	Үйл ажиллагааны ЦМГ	-10,029.57	14,200.10
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-4,105.00	0.00
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	15,000.00	(15,000.00)
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	10,664.97	(14,965.60)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	132.69	998.13
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	998.13	198.22
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	215,432.02	282,116.36
	Урсгал зардал	215,432.02	282,116.36
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	190,274.79	280,992.36
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	190,274.79	280,992.36
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 46.3 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитаар залруулсан. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Мөнгөн гүйлгээний тайланд зардлыг 24.0 сая төгрөгөөр, үр дүнгийн тайланд зардлыг 13.5 сая төгрөгөөр, авлагыг 3.2 сая төгрөгөөр, өглөгийг 5.4 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн алдаа гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 161.2 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 5.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 155.9 сая төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 11 заалт албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

- ✓ Ажилчдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 0.6 сая төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно."-г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Ажиллагсдаас 0.2 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" -г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж гар утасны төлбөрт 0.5 сая төгрөг, хэвлэл захиалгын төлбөрт 0.05 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12.1.1.гар утасны зардал; 12.1.3.хэвлэлийн захиалгын төлбөр"-г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Түлш халаалтын тендерт шалгарсан үнэ, гэрээний үнийн дүнгээс илүү үнээр худалдан авалт хийж 0.1 сая төгрөгийг бэлтгэн нийлүүлэгчид илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6-т "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлаг байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санаамааргүй үйлдэл, оо үйлдэл.

санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх"; Засаг даргын тамгын газрын нүүрс, модон түлш нийлүүлэх тендерийн баримт бичгийн 4.1-т "Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана", Нүүрс худалдан авах гэрээний 1.2-т "Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 1 тонныг тендерт ялсан үнэ болох 125,000 төгрөгөөр тооцож, 2023.05.15-ны өдрийг дуустал хугацаанд нийт 550 тонн нүүрсийг, 68,750,000 төгрөгөөр нийлүүлнэ"-г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Худалдан авах гэрээний хүрээнд нүүрс худалдан авалт хийж байгаа боловч нүүрс татах шатахуунд 3.4 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4-т Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"- г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна
- ✓ Өмнөх оны өглөгийг барагдуулахдаа 0.2 сая төгрөгийг илүү шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4-т Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;"-г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ **3.2 Албан шаардлага**
- ✓ Нийгмийн даатгалын хэлтэст 0.9 сая төгрөгийн цалин илүү, 1.1 сая төгрөгийн цалин дутуу тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1-т "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ", 17.1.1-т "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", 17.1.2-т "Шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх"-г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Түлш халаалтын тендерт шалгараагүй иргэнээс 7.5 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно"-г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Шатахууны тооцоо хийхэд 5.3 сая төгрөгийн шатахуун замын хуудасгүй зарцуулж шууд зардалд бичсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"-г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Ажилчдад дотоод журамд зааснаас 4.0 сая төгрөгийн илүү нүүрс олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Байгууллагын дотоод журмын 9.3-т "Байгууллагын нийт ажилтнуудад жилд 1 удаа түлээ нүүрсний тусламж үнэ төлбөргүй үзүүлнэ. Нэг хүнд 2 тн нүүрс жагсаалтаар олгож байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"-г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Уурын зуухны тогоо тээвэрлэн авчрахтай холбоотой 16.4 сая төгрөгийн зардал гарсан боловч зуухны тогоо ажиллахгүй байгаа нь төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулсан байна. Аудитаар анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах; 14.2.5.өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах; 14.2.10.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, 40.4.1.төсвийн үр дүнг сайжруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар үүрэг өгч, хяналт тавьж ажиллах"-г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Нягтлан бодогчийн хамаарал бүхий этгээдээс 14.8 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно"-г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Зардлын төлөвлөгөөг 72.9 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж алдагдалтай ажилласан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах"; Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 113 тогтоолыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн татварын дүн нийт худалдан авалт хийсэн дүнгээс зөрүүтэй тайлагнасан. Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлангийн өглөгийн эхний үлдэгдлийг мөнгө гаргаагүй боловч өмнөх үеийн үр дүнгийн зардалд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер,

бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."-г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний 19.2 сая төгрөгийг И баримтгүй гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."-г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, таван саяас дээш 30 орлого, зарлагын гүйлгээнээс 3 мэдээллийг мэдээлээгүй, 6 тушаал шийдвэрээс 6 тушаалыг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-т "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр."-г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруула агүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрдэнэ сумын Эрчим хүч ААТҮГ	4	46.28	2	8.68	2	36.93	4	45.61				
Дүн	4	46.28	2	8.68	2	36.93	4	45.61				



Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч ута	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага		Хууль,		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
"Эрдэнэ сумын Эрчим хүч" ААТҮГ	15	141.97	6	5.31	9	136.66	0	-				-	-
Дүн	15	141.97	6	5.31	9	136.66	0	-	0	0		-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг дутуу мэдээллэсэн	1	-	-	-	1		-	-
Дүн	1	0	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний и баримтгүй гүйлгээ хийсэн	1	19.26	-	-	1	19.26		-
Дүн	1	19.3	-	-	1.0	19.3	0	-
Нийт дүн	2	19.3	-	-	2.0	19.3	0	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	1	-	-
	НИЙТ	1	1	-	-	-	1	-	-

